

**БАТЛАВ:**

“Амгалан дулааны станц” ТӨХК-  
ийн

Гүйцэтгэх захирал

/ Ш.БАЯНМОНХ /

/Гарын үсэг/

**БАТЛАВ:**

“Монкран Консалтинг” ХХК-ийн

Гүйцэтгэх захирал

МОНКРАН  
КОНСАЛТИНГ  
ХХК

/ Б. НАРАНГЭРЭЛ /

/Гарын үсэг/  
5883849 1116229483

## ӨРГӨХ ЗӨӨХ МЕХАНИЗМД ТЕХНИКИЙН МАГАДЛАЛЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 оны 03 сарын 09 өдөр.

№24  
2022

Улаанбаатар хот

**Нэг талаас:** Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 – р хороо УС-15-1-1 тоот хаягт орших **Амгалан Дулааны станц ТӨХК** (“Захиалагч”) –ийг төлөөлж гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх

**Нэгөө талаас:** Монгол Улс, Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 3 – р хороо Бармаш төв # 105 тоот хаягт орших **Монкран Консалтинг ХХК** (“Үйлчилгээ үзүүлэлт”) –ийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Нарангэрэл

нарын хооронд энд дурдсан тохиролцоог харгалзан үзэж, дараах зүйлийг дагаж мөрдөхөөр харилцан тохиролцов:

### 1. ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

1.1. Үйлчилгээ үзүүлэлт нь энэхүү Гэрээнд заасан нөхцлөөр дараах мэргэжлийн үйлчилгээг Компанид үзүүлнэ. Үүнд:

- Захиалагчийн үйл ажиллагаанд ашиглаж буй
- Гүүрэн кран болон цахилгаан талийн техникийн магадлалыг хийнэ.

1.2. Компани нь Үйлчилгээ үзүүлэгчид сургалтын үйлчилгээний захиалгыг арав хоногийн өмнө, бусад үйлчилгээний захиалгыг тав хоногийн өмнө өгч байна.

1.3. Үйлчилгээ үзүүлэлт нь 1.1-д заасан үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу авч, энэхүү гэрээний хугацаанд уг тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байдлыг хангах бөгөөд үйлчилгээг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, дүрэм, шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

## **2. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС БОЛОН ТӨЛБӨР ХИЙХ ЖУРАМ**

- 2.1. Үйлчилгээний хөлсийг Хавсралт 1- д заасан тарифын дагуу төлнө.
- 2.2. Үйлчилгээний хөлсөнд зөвхөн ажлын хөлс багтсан болно.
- 2.3. Захиалагч нь үйлчилгээний хөлсийг төлбөрийн нэхэмжлэл хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Үйлчилгээ үзүүлэгчийн нэхэмжлэхэд заасан дансанд шилжүүлнэ.

## **3. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1. Захиалагч нь Үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлж буй үйлчилгээнд хяналт тавих, мэргэжлийн түвшинд чанартай, доголдолгүй ажил үйлчилгээгээр хангахыг шаардах эрхтэй.
- 3.2. **Захиалагч нь дараах эрх, үүрэгтэй:**

### **a. Захиалагч нь дараах үүрэгтэй**

- I. Хавсралтад заасан тарифаар тооцон үйлчилгээний төлбөрийг төлөх;
- II. Үйлчилгээ үзүүлж байгаа мэргэжилтний зөвлөгөөг хөдөлмөрийн болон техникийн аюулгүй ажиллагаандаа баримтлах
- III. Ашиглаж байгаа техник, хэрэгслийн талаар үйлчилгээ үзүүлэгчээс шаардсан мэдээлэл, материалыг гаргаж өгөх
- IV. Өргөх механизм талаар Монгол Улсын болон Олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн норм, стандартыг, мөн үйлчилгээ үзүүлэгчийн Зөвлөгөөг горимын дагуу хэрэгжүүлээгүйгээс бий болсон осол, аваарь, аливаа эрсдлийг дангаар хариуцах үүрэгтэй.
- V. Засвар үйлчилгээг явуулахад шаардагдах ажлын нөхцөлийг бүрдүүлж өгөх.
- VI. Хууль, гэрээнд заасан бусад үүрэг

### **b. Захиалагч нь дараах эрхтэй:**

- I. Үйлчилгээний явцад хяналт тавих, шаардлагатай, санал, заавар, дүгнэлтийг зөвлөгөө өгч буй мэргэжилтэнд болон үйлчилгээ үзүүлэгчийн удирдлагад бичгээр гаргах;
- II. Үйлчилгээ үзүүлэгч тал Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол Гэрээг цуцлах саналыг үйлчилгээ үзүүлэгч талд хүргүүлэх
- III. Үйлчилгээ үзүүлэгч талын үзүүлсэн үйлчилгээний доголдлын улмаас компанийд болон гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд түүнийг арилгах, учирсан хохирлыг барагдуулахыг шаардах эрхтэй;
- IV. Бүх үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд, төлөвлөгөөний дагуу, хугацаанд нь явуулахыг шаардах;
- V. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг үйлчилгээ үзүүлэгч талаас шаардах.

### **3.3. Үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрх, үүрэгтэй:**

а. Үйлчилгээ үзүүлэгч нь дараах үүрэгтэй:

- I. Үйлчилгээг Гэрээнд заасан нөхцлөөр, чанарын өндөр түвшинд тохирлцсон хугацаандаа зохион байгуулах;
- II. Үйлчилгээний чанартай холбогдуулан санал, заавар, дүгнэлт өгвөл хүлээн авах, тусгах, биелүүлэх;
- III. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж авсан, мэдсэн Компанид холбогдолтой аливаа мэдээлэл, баримт материалын нууцлалыг чанд хадгалах, өөрийн болон бусдын ашиг сонирхолд ашиглуулахгүй, задруулахгүй, нийтэд ил болгохгүй байх;
- IV. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй нөхцөлд Захиалагч болон түүний ажилтан, гуравдагч этгээдэд учирсан хохирол, зардлыг бүрэн барагдуулах;
- V. Гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх;

б. Үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрхтэй:

- I. Гэрээнд заасан журмаар Захиалагчаас үйлчилгээний төлбөрийг шаардаж авах;
- II. Гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэхийг Захиалагчаас шаардах.
- III. Үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнийг орон байр, хэвийн ажиллах бусад нөхцлөөр хангахыг шаардах
- IV. Үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтний зүй ёсны санал, шаардлагыг тухай бүр хэрэгжүүлэхийг шаардах, ийнхүү хэрэгжүүлээгүйгээс үссэн аливаа эрсдэл, хохирлыг хариуцахгүй байх
- V. Захиалагчаас ашиглаж байгаа техникийн талаарх бодит мэдээллийг гаргуулахаар хүсэлт гаргуулах, үүнийг биелүүлэхийг шаардах эрхтэй.
- VI. Зөвлөх үйлчилгээ болон угсралт, техник үйлчилгээ, засвар, сургалтын үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэхийг шаардах, ийнхүү нөхцлийг бүрдүүлээгүйгээс үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлснөөс үүдсэн эрсдэл, хариуцлагыг хүлээхгүй байх
- VII. Засвар үйлчилгээ үзүүлэхдээ Хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангах үүрэгтэй. Хэрэв үйлчилгээ үзүүлэгчийн буруугаас хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаагүй, аюул, осол болсон тохиолдолд түүнийг бүрэн хариуцах үүрэгтэй.

## **4. ХАРИУЦЛАГА**

4.1. Талууд хууль болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талд учирсан хохирлыг нэн даруй арилгах үүрэгтэй.

4.2. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр талууд гэрээгээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс аль нэг талд учруулсан хохирлыг хариуцахгүй бөгөөд харин дээрх хохирлыг арилгахад харилцан туслах үүрэг хүлээнэ.

## **5. ГЭРЭЭНД ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ БОЛОН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

Энэхүү гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан бөгөөд гэрээнд Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа Монгол Улсын хууль тогтоомж үйлчилнэ. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг Захиалагч болон Үйлчилгээ үзүүлэгч харилцан зөвшилцэж шийдвэрлэж чадаагүй тохиолдолд, аль нэг тал шүүхэд нэхэмжлэл гаргасан бол уг маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхээр талууд тохиролцов.

## **6. ГЭРЭЭНИЙ ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА**

Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж тамгалсанаар хүчин төгөлдөр болох бөгөөд ажлын 10 хоногт хүчин төгөлдөр үйлчилнэ. Гэрээний хүчинтэй хугацаа дуусгавар болохоос 3 хоногийн өмнө аль нэг тал нөгөө талдаа гэрээг дуусгавар болгох, эсхүл энэхүү гэрээний 9-р зүйлд заасны дагуу гэрээг цуцлах тухайгаа бичгээр мэдэгдээгүй бол энэхүү гэрээний хугацааг дахин 10 хоногоор сунгагдсанд тооцно.

## **7. ГЭРЭЭ ЦУЦЛАХ**

- 7.1. Хэрэв Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн аль нэг үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол Захиалагч нь Үйлчилгээ үзүүлэгчид энэ талаар бичгээр мэдэгдэх шаардлагыг хангаагүй бол, эсхүл эрх бүхий байгууллагаас Үйлчилгээг үзүүлэгчийн үйл ажиллагааг зогсоосон, гэрээний 1.3-т заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, цуцалсан бол Захиалагч энэхүү гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй. Ийнхүү цуцалсан бол Захиалагч энэхүү гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй. Ийнхүү гэрээг цуцлах нь нэмэлт шинжтэй бөгөөд хууль болон энэхүү гэрээний дагуух гэрээг цуцлах нь нэмэлт шинжтэй бөгөөд хууль болон энэхүү гэрээний дагуух Захиалагчийн эдлэх аливаа эрх, хохирол барагдуулах үйл ажиллагааг мөн адил хэрэгжүүлнэ. Гэрээг цуцалснаар Захиалагч нь Үйлчилгээ үзүүлэгчийн өмнө аливаа нөхөн төлбөр төлөх үүрэг хүлээхгүй.
- 7.2. Хэрэв аль нэг тал дампуурсныг шүүх тогтоосон бол энэхүү гэрээ нь автоматаар цуцлагдана. Энэ тохиолдолд аль нэг тал нөгөө талаасаа аливаа нөхөн төлбөр авах эрх эдлэхгүй бөгөөд гэхдээ үүнд ийнхүү гэрээг цуцлахаас өмнө энэ гэрээний аль нэг эдлэхгүй бөгөөд тус бүр нэг (1) эх хувийг хадгална.

## **8. БУСАД**

- 8.1. Талуудын эрх бүхий төлөөлөгчид бичгээр тохиролцсоноос бусад тохиолдолд энэхүү гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
- 8.2. Энэхүү гэрээг Монгол хэлээр 2 хувь үйлдсэн бөгөөд Захиалагч болон Үйлчилгээ үзүүлэгч тус бүр нэг (1) эх хувийг хадгална.

Дээрхийг гэрчлэн талууд энэхүү гэрээг дээр дурдсан өдөр Улаанбаатар хотноо байгуулав.

31	ЛК №3а,б-ийн толгой	CD3	3тн	200,000₮
32	ЛК №4а,б-ийн толгой	CD3	3тн	200,000₮
33	ЛК №5а,б-ийн толгой	CD3	3тн	200,000₮
34	ЛК №6-ийн толгой	CD3	3тн	200,000₮
35	ЛК №7-ийн төгсгөлд туз чангалах өрөө	CD3	3тн	200,000₮
36	ЛК №7-ийн конвейрийн толгой хэсэг	CD3	3тн	200,000₮
37	Чичиргээт шигшүүр а,б	MD5	5тн	250,000₮
38	Бутлуур а,б	MD10	10тн	250,000₮
39	Бутлуур а,б	MD10	10тн	250,000₮
40	Нуруулдан овоологч	MD1	3тн	250,000₮
<b>Нийт үнийн дун / НӨАТ багтсан /</b>				<b>9,000,000₮</b>

№	Байршил	Тип марк	Даац	Техникийн магадлал үнэ
1	Сулжээний усны насосны өрөө	MD10	10тн	250,000₮
2	Компрессорын аж ахуй	MD5	5тн	250,000₮
3	Утаа сорогч №1	MD10	10тн	250,000₮
4	Утаа сорогч №2	MD10	10тн	250,000₮
5	Утаат шүүлтүүр №1 А секц	CD1	1тн	200,000₮
6	Утаат шүүлтүүр №1 Б секц	CD1	1тн	200,000₮
7	Утаат шүүлтүүр №2 А секц	CD1	1тн	200,000₮
8	Утаат шүүлтүүр №2 Б секц	CD1	1тн	200,000₮
9	Утаат шүүлтүүр №3 А секц	CD1	1тн	200,000₮
10	Утаат шүүлтүүр №3 Б секц	CD1	1тн	200,000₮
11	0-м тэмдэгтийн зуух №1 А тал	MD5	5тн	250,000₮
12	0-м тэмдэгтийн зуух №1 Б тал	MD5	5тн	250,000₮
13	0-м тэмдэгтийн зуух №2 А тал	MD5	5тн	250,000₮
14	0-м тэмдэгтийн зуух №2 Б тал	MD5	5тн	250,000₮
15	0-м тэмдэгтийн зуух №3 А тал	MD5	5тн	250,000₮
16	0-м тэмдэгтийн зуух №3 Б тал	MD5	5тн	250,000₮
17	Механик цех	LD5	5тн	250,000₮
18	Шаарганы бункер №1 дээр	LX2	2тн	200,000₮
19	Шаарганы бункер №2 дээр	LX2	2тн	200,000₮
20	Нарийн үнсний бункерийн дээр	CD1	1тн	200,000₮
21	Үндсэн барилгын тааз	CD1	1тн	200,000₮
22	Хөргөлтийн насосны байр	LX2	2тн	200,000₮
23	Шохойн чулууны №1-н байрны дээр	LX2	2тн	200,000₮
24	Шохойн чулууны №2-н байрны дээр	LX2	2тн	200,000₮
25	Насос станцын байр	LX2	2тн	200,000₮
26	Вагон хөмрөгчийн 0 тувшин	LH20/5t	20/5	350,000₮
27	Туузан тэжээгч -1	MD5	5тн	250,000₮
28	Туузан тэжээгч -1	MD5	5тн	250,000₮
29	ЛК №1,2-ийн толгой	CD3	3тн	200,000₮
30	ЛК №3а,б-ийн толгой	CD3	3тн	200,000₮

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК:**

/Гарын үсэг/

Нэр: П.Зоригтоо

Албан тушаал: Хяналтын хэлтсийн  
дарга



/Гарын үсэг/

Нэр: Г. Эрдэнэбилэг

Албан тушаал: Хангамжийн хэлтсийн  
дарга



/Гарын үсэг/

Нэр: О.Удвал

Албан тушаал: СЭЗХ-ийн дарга  
бөгөөд Ерөнхий нягтлан бодогчийн  
ажил үүргийг түр орлог гүйцэтгэгч



**МОНКРАН КОНСАЛТИНГ ХХК:**



/Гарын үсэг/

Нэр: Н.Чимэдрэгзэн

Албан тушаал: Техникийн менежер